

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/181/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.14 № 59

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.ТӨГСБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9 болон 8 дугаар зүйлийн 8.1, 8.1 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Орон нутгийн төсөв Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 4.3 сая төгрөгийг олгосон байна. Жилийн эцсээр 0.8 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн

006020064

байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын дагуу анхан шатны баримтаар тулган шалгаж үзэхэд 2021 онд гэрэл цахилгаан 7.2 сая, 2022 онд 7.6 сая төгрөг өмнөх оноос 0.4 сая төгрөгийг илүү зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дах заалтаар байгууллагын хэмжээнд дотоод сүлжээ ашиглаж албан бичиг, тоотыг төлөвлөж ажиллаж байгаа ч өмнөх онтой харьцуулж үзэхэд 2021 онд 3.3 сая, 2022 онд 4.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь тайлант онд 1.5 сая төгрөгийн бичиг хэргийн зардал өмнөх оноос илүү зарцуулсан.

Өмнөх онтой харьцуулахад хэмнэлт үүсээгүй шалтгаан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/07 тоот тушаалаар:

1. Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үе шаттайгаар шилжүүлэх ажлын хүрээнд 5 аймгийг онцолж 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс зохион байгуулж ажиллах

2. Шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан этгээдийг хүлээн авч, баривчлах байрны үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах гэсэн тушаал шийдвэр гарснаар 2022 онд 423 шүүхийн шийдвэртэй иргэнийг баривчилгаанд оруулснаар цахилгаан эрчим хүч, хоол хүнс, түлш халаалт, бичиг хэргийн зардал өмнөх оныхоос илүү зарцуулагдсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	67074162.00	70507086.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	616200.00	346000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	616200.00	346000.00
3121	Төгрөг	616200.00	346000.00
31211	Төрийн сангийн харилцах	616200.00	346000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66457962.00	70161086.46
351	Түүхий эд материал	41442694.90	42505437.91
35110	Тусгай зориулалттай материал	41128578.10	41742578.11
35130	Эм боох материал	314116.80	762859.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3254968.95	596581.00
354	Хангамжийн материал	16555298.15	22569067.55
35420	Аж ахуйн материал	12526072.60	12420007.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	620000.00
35450	Барилгын засварын материал	858930.55	858930.55
35460	Хүнсний материал	3170295.00	8670130.00
35600	Мал амьтад	5205000.00	4490000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1270168329.30	1270836934.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1270168329.30	1270836934.20
392	Биет хөрөнгө	1024631970.23	1019974934.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	996476386.49	995626386.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64995336.76	-85527115.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	138500000.00	95500000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91416666.46	-61499999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97926919.20	99629691.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65140494.80	-35795902.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17438158.00	19936854.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7856995.44	-11594978.91
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3700000.00	3700000.00
393	Биет бус хөрөнгө	245536359.07	250862000.00
39301	Програм хангамж	6417692.31	5500000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	245362000.00	245362000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1337242491.30	1341344020.66
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1336626291.30	1341344020.66
51	Засгийн газрын хувь оролцоо	1336626291.30	1341344020.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337072727.16	337072727.16
51101	Өмч: - төрийн	337072727.16	337072727.16
512	Хуримтлагдсан үр дүн	651153321.86	655871051.22
51210	Өмнөх үеийн үр дүн	625797364.91	651153321.86
51220	Тайлант үеийн үр дүн	25355956.95	4717729.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	348400242.28	348400242.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1337242491.30	1341344020.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	671527918.75	745851233.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43836718.75	70875933.01
120	Нийтлэг татварын бус орлого	43836718.75	70875933.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43836718.75	70875933.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	925000.00	25478800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42911718.75	45397133.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627691200.00	674975300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	598391100.00	667015400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	598391100.00	667015400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29300100.00	7959900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29300100.00	4325000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3634900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	659840164.80	741133503.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	659840164.80	741133503.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	655168885.32	736745533.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444146296.63	467171644.84
210101	Үндсэн цалин	276134100.00	292376556.58
210102	Нэмэгдэл	165492196.63	166086664.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1080000.00	1104000.00
210104	Урамшуулал	1440000.00	7604423.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8860092.89	9391885.41
210205	Эрүүл мэндийн даатгал	8860092.89	9391885.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77510900.00	104088100.00
210301	Гэрэл, цахилгаан	7220263.93	7627722.41
210302	Түлш, халаалт	66194038.07	93747624.71
210303	Цэвэр, бохир ус	4096598.00	2712752.88
2104	Хангамж, бараа материалын зардал	16028450.00	23617200.00
210401	Бичиг хэрэг	3888850.00	4397500.00
210402	Тээвэр, шатахуун	8930700.00	14478800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1169400.00	969900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249100.00	203500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1035400.00	3197500.00
210408	Бараа материал акталсны зардал	755000.00	370000.00
2105	Нормативт зардал	33032807.10	48285975.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1017738.20	1513457.00
210502	Хоол, хүнс	29914000.00	42658965.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2101068.90	4113553.55
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25846303.00	29359650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	161500.00	134000.00
210604	Урсгал засвар	25684803.00	29225650.00
2107	Томилолт, зочны зардал	374000.00	449600.00
210702	Дотоод албан томилолт	374000.00	449600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3392856.00	3035400.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1736700.00	1603200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	326325.00	280200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143000.00	120400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	954500.00	802100.00
210807	Газрын төлбөр	232331.00	229500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45977179.70	51346078.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	380000.00	665100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130875.00	197200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45466304.70	50483778.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4671279.48	4387969.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	3096000.00	3590600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3096000.00	3590600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1306479.48	797369.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1306479.48	797369.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>11687753.95</u>	<u>4717729.36</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>8101753.95</u>	<u>4717729.36</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	652134983.52	705144230.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8496060.00	30966300.00
120	Нийтлэг татварын бус орлого	8496060.00	30966300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5820060.00	26966300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5820060.00	26966300.00
120009	Бусад орлого	2676000.00	4000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	643638923.52	674177930.25
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	597084620.52	666218030.25
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	597084620.52	666218030.25
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46554303.00	7959900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29300100.00	4325000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3634900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	651868783.52	705414430.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	651868783.52	705414430.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	648503983.52	701823830.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446822296.63	471171644.84
210101	Үндсэн цалин	278810100.00	296376556.58
210102	Нэмэгдэл	165492196.63	166086664.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1080000.00	1104000.00
210104	Урамшуулал	1440000.00	7604423.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8860092.89	9391885.41
210205	Эрүүл мэндийн даатгал	8860092.89	9391885.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77510900.00	104088100.00
210301	Гэрэл, цахилгаан	7220263.93	7627722.41
210302	Түлш, халаалт	66194038.07	93747624.71
210303	Цэвэр, бохир ус	4096598.00	2712752.88
2104	Хангамж, бараа материалын зардал	14582300.00	24321700.00

210401	Бичиг хэрэг	3280800.00	4805500.00
210402	Тээвэр, шатахуун	8887600.00	15643800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1169400.00	969900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249100.00	203500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995400.00	2699000.00
2105	Нормативт зардал	27855500.00	47863500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	830800.00	1649700.00
210502	Хоол, хүнс	27024700.00	46213800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63966303.00	38536000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43324000.00	9706600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	161500.00	134000.00
210604	Урсгал засвар	16280803.00	28695400.00
2107	Томилолт, зочны зардал	374000.00	449600.00
210702	Дотоод албан томилолт	374000.00	449600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8021716.00	5139100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6365560.00	3706900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	326325.00	280200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143000.00	120400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	954500.00	802100.00
210807	Газрын төлбөр	232331.00	229500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	510875.00	862300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	380000.00	665100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130875.00	197200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3364800.00	3590600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3096000.00	3590600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3096000.00	3590600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	266200.00	-270200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	266200.00	-270200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	350000.00	616200.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	616200.00	346000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
CO 1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	625,797,364.91		1,311,270,334.35
CO 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	625,797,364.91	0.00	1,311,270,334.35
CO 7	Тайлант үеийн үр дүн			25,355,956.95		25,355,956.95

C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	651,153,321.86	0.00	1,336,626,291.30
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	676,509,278.81	0.00	1,336,626,291.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	651,153,321.86	0.00	1,336,626,291.30
D08	Тайлант үеийн үр дүн			4,717,729.36		4,717,729.36
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,072,727.16	348,400,242.28	655,871,051.22	0.00	1,341,344,020.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	700454100.00	705414430.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	700454100.00	705414430.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	698863500.00	701823830.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	471241700.00	471171644.84
210101	Үндсэн цалин			297731600.00	296376556.58
210102	Нэмэгдэл			170990100.00	166086664.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт			1080000.00	1104000.00
210104	Урамшуулал			1440000.00	7604423.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	10119200.00	9391885.41
210205	Эрүүл мэндийн даатгал			10119200.00	9391885.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	104088100.00	104088100.00
210301	Гэрэл, цахилгаан			6036900.00	7627722.41
210302	Түлш, халаалт			94920100.00	93747624.71
210303	Цэвэр, бохир ус			3131100.00	2712752.88
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	24321700.00	24321700.00
210401	Бичиг хэрэг			4805500.00	4805500.00
210402	Тээвэр, шатахуун			15643800.00	15643800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			969900.00	969900.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			203500.00	203500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			2699000.00	2699000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00	46363500.00	47863500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			1649700.00	1649700.00
210502	Хоол, хүнс			44713800.00	46213800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	38536000.00	38536000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл			9706600.00	9706600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			134000.00	134000.00
210604	Урсгал засвар			28695400.00	28695400.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00	449600.00	449600.00
210702	Дотоод албан томилолт			449600.00	449600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	2881400.00	5139100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			2251300.00	3706900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар			280200.00	280200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			120400.00	120400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ			0.00	802100.00
210807	Газрын төлбөр			229500.00	229500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	862300.00	862300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			665100.00	665100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			197200.00	197200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	1590600.00	3590600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	1590600.00	3590600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			1590600.00	3590600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	692494200.00	694779069.75
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	667015400.00	667812769.75
131001	Улсын төсвөөс санхүүжих			667015400.00	667812769.75

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	25478800.00	26966300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			25478800.00	26966300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				616200.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				346000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30168900.00	7959900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30168900.00	7959900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30168900.00	7959900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	1234900.00
210302	Түлш, халаалт	0.00	1234900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1418900.00	1325000.00
210401	Бичиг хэрэг	1300100.00	500000.00
210402	Тээвэр, шатахуун	118800.00	825000.00
2105	Нормативт зардал	0.00	2400000.00
210502	Хоол, хүнс	0.00	2400000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28750000.00	3000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28750000.00	3000000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29300100.00	7959900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29300100.00	7959900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29300100.00	4325000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3634900.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		616200.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		346000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх.” гэсэн зорилготой.

Зорилт:

1. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүгчийн шийдвэрийг гүйцэтгэх, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх
2. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн зарим төрлийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нэгдсэн тоо бүртгэл хөтөлж хяналт тавих
3. Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх
4. Хоригдлын аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажлыг боловсронгуй болгох
5. Хоригдлын дунд явуулж буй нийгэмшүүлэх ажлыг орчин үеийн нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуудан хэрэгжүүлэх, хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох
6. Хоригдлын дунд явуулах ерөнхий боловсролын болон мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг идэвхжүүлснээрээ хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
7. Хоригдлын эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах
8. Гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгаж хохирогчид шилжүүлэх
9. Нийгэмд аюултай халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтой ялтныг албадан эмчлэх
10. Иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх
11. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналт шалгалтын ажилтантай тус хяналт нь улирлаар үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.1 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	161,200	346,000	-184800
Авлага	0	0	0
Бараа материал	66,457,962	70,161,086.46	-3,703,125
Үндсэн хөрөнгө	1,270,168,329.3	1,270,836,934.2	-668,605
Нийт хөрөнгө	1,337,242,491.3	1,341,344,020.66	-4,101,530
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,336,626,291.3	1,341,344,020.66	-4,717,730
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,337,242,491.3	1,341,344,020.66	-4,101,530

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Нийт хөрөнгө буюу үндсэн хөрөнгийг 4.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт зэрэг нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос нэмэгдсэн шалтгаанаар өөрчлөлт гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн нийт зарлагыг 717.06 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 717,06 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 24.5 сая төгрөгөөр бууруулж, 694.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч үндсэн хөрөнгө бэлтгэх саналыг хасаж баталсан шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 24.5 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 38 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,279.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 1.6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1609.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 53.04 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1562.5 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1640.1 сая, 53.04 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа /80101/	656,762.0	655,964.6	797.4	99.98
2	Туслах үйл ажиллагаа /80102/	20,657.8	20,657.8	0	100
3	Холбооны суваг ашигласны хөлс /80220/	955.7	955.7	0	100
4	Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ /80229/	7,707.1	7,707.1	0	100
5	Шүүхийн шийдвэрийн үйлдвэрлэлийн арга хэмжээ /80235/	4,821.0	4,821.0	0	100
6	Ажил ологчоос олгох тэтгэмж	1,590.6	1,590.6	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар 7.9 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл 4.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 3.6 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 6.9 сая төгрөгөөс 80 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж ажилласан. Мөн байгууллагын дотоод сүлжээг ашиглаж байгууллагын бичиг хэргийн зардлыг хэмнэсэн зэрэг арга хэмжээ авч ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн нь тус байгууллагын хувьд энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9 болон 8 дугаар зүйлийн 8.1, 8.1 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын дагуу анхан шатны баримтаар тулган шалгаж үзэхэд 2021 онд Гэрэл цахилгаан 7.2 сая, 2022 онд 7.6 сая төгрөг өмнөх оноос 0.4 сая төгрөгийг илүү зарцуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дах заалтаар Байгууллагын хэмжээнд дотоод сүлжээ ашиглаж албан бичиг, тоотыг гаргаж ажиллаж байгаа ч өмнөх онтой харьцуулж үзэхэд 2021 онд 3.3 сая, 2022 онд 4.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь тайлант онд 1.5 сая төгрөгийн бичиг хэргийн зардал өмнөх оноос илүү зарцуулсан байгаа нь тус хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

Өмнөх онтой харьцуулахад хэмнэлт үүсээгүй шалтгаан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/07 тоот тушаалаар:

1. Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үе шаттайгаар шилжүүлэх ажлын хүрээнд 5 аймгийг онцолж 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс зохион байгуулж ажиллах
2. Шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл оногдуулсан этгээдийг хүлээн авч, баривчлах байрны үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах гэсэн тушаал шийдвэр гарснаар 2022 онд 423 шүүхийн шийдвэртэй иргэнийг баривчилгаанд оруулснаар цахилгаан эрчим хүч, хоол хүнс, түлш халаалт, бичиг хэргийн зардал өмнөх оныхоос илүү зарцуулагдсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 оны Шилэн дансны мэдээллийн Шилэн дансны тухай хуулийн дагуу бүрэн мэдээлж ажиллажээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Орхон аймгийн Далай Ван хувийн аудитын байгууллагаар санхүүгийн тайлангаа баталгаажууж албан хаагчдад олгосон хөдөлмөрийн чадвар түр алдалтын дутуу тооцож олгосон буюу Цэргийн албаны хуультай холбоотой 1 зөвлөмж, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 1 албан шаардлагыг авсан байна. Энэ хүү зөвлөж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 сарын 23 өдрийн 1/724 тоот албан бичгээр биелэлтийг хангаж ажиллажээ.

4.5.1 Завсрын аудитын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бичсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллажээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	128,500	1	128,500	100
Зөвлөмж	1	107400	1	107400	100
Нийт дүн		235900		235900	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад алдаа¹ алдааг илрээгүй.

Аудитаар 231.0 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрч зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага бичигдээгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт:

Урсгал зардлаас Хануй цүүр, Батцэнгэл, Чимэгт-Ундрамаас материалын үнэ болох 231,000 төгрөгийн анхан шатны баримтгүй.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2. Ахмадын сантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг мөрдөж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь "сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

3. Тээвэр шатахуунтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны Жишиг норм батлах тухай 390 дүгээр тушаалыг мөрдөж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллах.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж^{3,4} ажиллах
2. Бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ШШГ Газар	3	231.0	0	0			3	231.0				
Дүн	3	231.0	0	0			1	231.0				

³ 15.2.1. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

⁴ 15.2.4. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх;